

Гадаад ажилчдын хүний эрхийг хамгаалах талаар авч хэрэгжүүлэх тогтолцооны гарын авлага

Ялгаварлан гадуурхалт, хүний эрхэнд халдах гэх мэт зүй бус үйлдлийг хориглодог.

① (Ажиллах нөхцөл) дотоодын ажилчдаас цалин хөлсийг ялгаатай олгох, цалин олгохгүй эсвэл хугацаанд нь олгохгүй зэрэг хөдөлмөрийн нөхцлийн ялгаа

- “Компаний байдал хэцүү байна”, “Гадаад ажилтан учраас” гэх шалтгаар **цалин хөлс**, төрөл бүрийн урамшуулал, **ажлаас халагдсаны тэтгэмжийн зөрүүг олгохгүй, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг зөрчих**
- “Ажил ихтэй байна”, “Мөнгө цуглуулах гэж ирсэн биз дээ?” гэж хүндэтгэх шалтгаангүйгээр **амралт болон ажлын цагийг зөрчих, жилийн цалинтай чөлөө олгохгүй байх** гэх мэт.

② (Үг хэлээр доромжлох, дайрах) Ажлын заавар, сургалт гэх мэтээр халхавчлан хэл амаар доромжлох, дарамтлах

- Ажлын шаардлага хүлээж аваагүй гэж хараах, биед халдах гэх мэт ажлын байран дахь **үг хэлээр доромжлох, дарамтлах**.
- Ажилд сургах шалтгаанаар хэмжээнээс хэтэрсэн байдлаар **хүрэх · бэлгийн дарамт үзүүлэх**

③ (Хүний эрхийн зөрчил) Ажлын байрнаас гадуурх төрөл бүрийн хүний эрхийн зөрчил

- Ажлын байранд гамшигийн нөхцөл үүсэх үед **аж үйлдвэрийн орчин дахь гамшигийн байдал** үүссэнийг мэдээлээгүй болон **нуун дарагдуулах**
- Гадаадын иргэн гэх шалтгаанаар үйлдвэрийн даатгал гэх мэтийн **нөхөн олговор хүсэх хүсэлтийг хааж боогдуулах**

④ (Хүний эрхэнд халдах) Ажлын байрнаас гадуурх төрөл бүрийн хүний эрхэнд халдах

- Хууль дүрэм зөрчсөн байгууламжинд байруулах(хүлэмж, контейнер гэх мэт), хэт их хэмжээний зардал цалингаас суутгах
- Биеийн байцаалт, гадаад паспортыг хурааж авах зэрэг зорчих эрхийг хязгаарлах зэрэг хүний үндсэн эрхэнд халдах

Хэрэв та ялгаварлан гадуурхалт, бусад зүй бус зүйлд өртвөл мэдээлэх боломжтой.

Мэдээлэл авах газар

Хөдөлмөрийн үндэсний газрын гомдол хүлээн авах газар, хөдөлмөр эрхлэлтийн төвийн олон хэлээр зөвлөгөө өгөх төв, гадаад ажилчидад зөвлөгөө өгөх төв гэх мэт.

※ Гадаад ажилчидад зөвлөгөө өгөх төв (Утас 1577-0071) өөр дамжуулан 17 орны хэлээр зөвлөгөө өгөх, мэдээлэл хүлээн авч дамжуулах боломжтой. <арын хэсэгт хаяг, холбогдох утасны дугаар>

Мэдээлэл хүсэлт авах өдөр

‘25. 8. 20.(Лхагва) аас эхлэн 7 хоног бүрийн Лхагва гариг, Хөдөлмөр эрхлэлтийн төв, гадаад ажилчдын тасгийн ‘Дуудлагаар мэдээлэл хүлээн авах төв’

“Таныг мэдээл өгсөн шалтгаанаар ямар нэгэн байдлаар хохироохгүйн тулд хамгаална.”

Ялгаварлан гадуурхалт зэрэг зүй бус харилцаатай тулгарвал ажлын байрыг солих боломжтой.

- Гадаадын ажилчид тус улсад анх ирэхдээ хөдөлмөрийн гэрээ байгуулсан ажлын байрандаа үргэлжлүүлэн ажиллах шаардлагатай боловч **хуульд заасан нөхцөл байдал** үүссэн тохиолдолд **ажлын байрыг солих** боломжтой. (Хамгийн эхний 3 жилд 3 удаа+1 жил 10 сарын хугацаанд 2 удаа)
- Тодруулбал, **амралтын өдөр · дампуурах**, ажил олгогчийн зүгээс **хөдөлмөрийн нөхцлийг зөрчсөн**(цалин хөлсийг олгоогүй, хугацаанд олгоогүй зэрэг) мөн **зү**, ажил олгогчийн зүгээс **хөдөлмөрийн нөхцлийг зөрчсөн**(цалин хөлсийг олгоогүй, хугацаанд олгоогүй зэрэг) мөн **зүй бус үйлдэл гаргасан** (бэлгийн дарамт, бэлгийн хүчирхийлэл, зодож танхайрах зэрэг) **орон сууцны барилга байгууламжийн стандарт зөрчсөн** гэх мэт гадаад ажилтны үүрэг хариуцлагад үл хамаарах шалтгаалан үүссэн зөрчлийн



Гадаад ажилчидад зөвлөгөө өгөх, мэдээлэл хүлээн авах байгууллага

Гадаад ажилчидад зөвлөгөө өгөх төв (Т. 1577-0071)

Хөдөлмөр эрхлэлтийн төвийн олон хэлээр зөвлөгөө өгөх төв (25. 8сарын байдлаар)

Харьяа	Зөвлөгөө өгөх боломжит хэл	Олон хэлээр зөвлөгөө өгөх төв	Харьяа	Зөвлөгөө өгөх боломжит хэл	Олон хэлээр зөвлөгөө өгөх төв
Төвийн хэсэг	Узбек хэл, Орос хэл	032-460-7135	Янсан	Мяньмар хэл	055-330-6448
	Тайланд хэл	032-460-7136		Англи хэл , Орос хэл	055-330-6450
	Вьетнам хэл	032-460-7137		Камбож хэл	055-330-6451
Инчон хойд хэсэг	Камбож хэл	032-540-2097		Хятад хэл	055-330-6432
Бүчон	Бангладеш, Англи хэл	031-999-0907		Непаль хэл, Хинди хэл	055-330-6446
	Индонези хэл	031-999-0908	Жинжү	Вьетнам хэл	055-760-6758
Өжонбү	Монгол хэл	031-828-0824		Вьетнам хэл	055-760-6759
	Непаль хэл, Пакистан хэл , Урдү хэл	031-828-0823	Тунён	Вьетнам хэл	055-730-1922
	Вьетнам хэл	031-828-0902	Дэгү	Хятад хэл	053-667-6047
	Камбож хэл	031-828-0901		Непаль хэл, Пакистан хэл	053-667-6048
	Мяньмар хэл	031-828-0903	Дэгү баруун хэсэг	Камбож хэл	053-605-6574
Гёнги	Узбек хэл	031-290-0879		Индонези хэл	053-605-6576
	Мяньмар хэл	031-289-2208		Филипин хэл, Англи хэл	053-605-6575
	Камбож хэл	031-290-0880	Пухан	Вьетнам хэл	054-288-3500
	Непаль хэл	031-290-0876	Гуанжү	Непаль хэл	062-609-8686
	Тайланд хэл	031-290-0888		Камбож хэл	062-609-8687
Анян	Вьетнам хэл	031-463-0774		Вьетнам хэл	062-609-8688
Ансан	Мяньмар хэл	031-496-1923		Индонези хэл, Зүүн Тимор хэл	062-609-8689
Пёнтэк	Индонези хэл	031-646-1217	Игсан	Непаль хэл, Хинди хэл	063-839-0040
	Хятад хэл	031-646-1213	Гүнсан	Вьетнам хэл	063-450-0607
Вонжү	Англи хэл, Энэтхэг хэл	033-769-0952	Дэжон	Вьетнам хэл	042-470-8326
Бүсан	Англи хэл, Индонези хэл	051-860-2026		Камбож хэл	042-470-8328
Бүсан баруун хэсэг	Индонези хэл	051-559-6606	Жонжү	Филипин хэл, Англи хэл	043-229-0755
Бүсан хойд хэсэг	Узбек хэл	051-330-9925	Чонан	Непаль хэл	041-620-9582
Чанвон	Хятад хэл	055-239-3553		Вьетнам хэл	041-620-7465
	Филипин хэл, Англи хэл	055-239-3552		Камбож хэл	041-620-9553
	Узбек хэл, Орос хэл	055-239-3551		Киргиз хэл, Орос хэл	041-620-9583
	Непаль хэл, Хинди хэл	055-239-3554		Непаль хэл, Англи хэл	043-850-4052
	Узбек хэл, Казах хэл	052-228-1913	Чүнжү	Вьетнам хэл	043-850-4051
Үлсан	Узбек хэл, Казах хэл	052-228-1913	Бурён	Вьетнам хэл	041-930-6267